



Худалдан авах ажиллагааны хяналт зохицуулалт /1-3/

- а. ХААБХ-ийн эрх, үүрэг
- б. ХАА-ны мэргэжлийн байгууллагын
эрх, үүрэг
- в. ХАА-ны улсын байцаагч
- г. Үнэлгээний хорооны эрх үүрэг, ёс
зүй

ХААБХэлтсийн үндсэн эрх үүрэг

Засгийн газрын худалдан авах ажиллагааны эрх зүйн орчинг сайжруулах зорилгоор:

- Худалдан авах ажиллагаатай холбогдсон хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулах
- Худалдан авах ажиллагаатай холбоотой дүрэм, журам, заавар, аргачлал, жишиг баримт бичгийн төслийг боловсруулах, хуулиар эрх олгосон бол батлах

à. Худалдан авах ажиллагааны бодлого зохицуулалт



Засгийн газрын худалдан авах ажиллагааг олон нийтэд ил тод болгох зорилгоор:

- Худалдан авах ажиллагааны мэдээ, мэдээлэл, тендер шалгаруулалтын зар, үр дүнг нийтэд түгээх зорилготой вэб хуудас хөтлөх, түүнд тендерийн урилга, бусад мэдээлэл тавих арга, хэлбэрийг тогтоох
- Захиалагчийн ирүүлсэн тайланг нэгтгэн, улсын хэмжээний худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн санг бүрдүүлж хөтлөх, нэгдсэн тоо баримт, мэдээлэл гаргах
- Энэ хуульд заасан тендерт оролцох эрх нь хязгаарлагдсан этгээдийн бүртгэлийг хөтлөх, хяналт тавих, мэдээлэх.

à. Худалдан авах ажиллагааны бодлого зохицуулалт



ЗГХАА-ны хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих зорилгоор:

- Энэ хуульд заасны дагуу тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянах, шийдвэрлэх
- Эрх бүхий хууль, хяналтын байгууллагын хүсэлтээр энэ хуулийн хэрэгжилттэй холбогдуулж тодорхой асуудал, асуулгад зөвлөмж тайлбар гаргах
- Худалдан авах ажиллагаатай холбоотой мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр захиалагчийг хангах
- Захиалагч худалдан авах ажиллагаанд зохих журмыг мөрдөж буй эсэхэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх



ҮРГЭЛЖЛЭЛ

- ... Мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтыг зохион байгуулах журмыг батлах.
- Захиалагчын үйл ажиллагаа, гэрээний биелэлт, чанарт явцын болон гүйцэтгэлийн хяналт, шинжилгээ, аудит хийх журмыг ТОГТООХ
- Хувийн хэвшлийн болон мэргэжлийн төрийн бус байгууллагыг энэ хуулийн 35-39 дүгээр зүйлд заасны дагуу сонгон шалгаруулж захиалагчийн үйл ажиллагаа, гэрээний биелэлт, чанарт явцын болон гүйцэтгэлийн хяналт, шинжилгээ, аудит хийлгэж болно.



ҮРГЭЛЖЛЭЛ

- Худалдан авах ажиллагааны асуудлаар олон улсын байгууллага, гадаадын бусад байгууллагатай хамтран ажиллах, энэ чиглэлээр олгосон техник туслалцааг төлөвлөх, зохицуулах
- Худалдан авах ажиллагаанд мэдээллийн технологи, цахим хэрэгслийг нэвтрүүлэх нөхцөл журмыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

а. Худалдан авах ажиллагааны бодлого зохицуулалт



Цахим худалдан авах ажиллагаа

Засгийн газрын худалдан авах ажиллагааны вэб хуудас-аг холбогдол

- Засгийн газрын үйл ажиллагааны ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх
- ЗГХАА-ны талаарх дүрэм журам, мэдээллийг олон нийтэд шуурхай хүргэх
- Энэ чиглэлээр хийх сургалт, сурталчилгааг хямд, үр ашигтай болгох
- Томоохон тендер шалгаруулалтын зарын хүртээмжийг нэмэгдүүлэх
- Томоохон худалдан авах ажиллагааны үр дүн буюу гэрээ байгуулах эрх авсан гүйцэтгэгчийг олон нийтэд мэдээлэх

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ЧИГ ҮҮРЭГ

- Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага нь энэ хуулиар эрх олгогдсон худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байна.
- Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжих, бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий нэгжтэй байна.
- Аймаг нийслэлийн засаг даргын дэргэдэх худалдан авах ажиллагааны нэгжийн даргыг тухайн аймаг, нийслэлийн засаг дарга худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын даргатай, дүүргийн засаг даргын дэргэдэх худалдан авах ажиллагааны нэгжийн даргыг дүүргийн засаг дарга Нийслэлийн засаг даргатай тус тус зөвшилцөн томилж чөлөөлнө.

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ЧИГ ҮҮРЭГ

- Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын болон нэгжийн дарга нь ял шийтгэлгүй, төрийн албанд 10-с доошгүй жил, үүнээс худалдан авах ажиллагааны чиглэлээр 3-с доошгүй жил ажилласан байна.
- Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага нь энэ хуульд заасан захиалагчийн эрх, үүргээс гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
 - Худалдан авах ажиллагааны нэгжийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах,
 - Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг зохион байгуулах,

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ЧИГ ҮҮРЭГ

- Худалдан авах ажиллагааны талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж, саналаа санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх,
- Худалдан авах ажиллагааны мэдээ, мэдээлэл, тендер шалгаруулалтын зар, үр дүнг нийтэд түгээх вэб хуудас хөтлөх, түүнд тендерийн урилга, бусад мэдээлэл тавих арга, хэлбэрийг тогтоох, боловсронгуй болгох,
- Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын чадавхи, техник технологи, програм хангамжийн хүчин чадлыг сайжруулах асуудлыг нэгдсэн бодлого, төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх,
- Энэ хуулийн 5.1.23-т заасан ерөнхий гэрээг байгуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Худалдан авах ажиллагааны үйл ажиллагаатай холбоотой хуульд заасан бусад чиг үүрэг.

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ЧИГ ҮҮРЭГ

- Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих журмыг Засгийн газар батална.
- Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага нь өөрийн гүйцэтгэх ажлын тодорхой хэсгийг хувийн хэвшлийн болон мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх бөгөөд нийт зарлах тендерийн 20-с доошгүй хувийг цахим худалдан авалтын хэлбэрээр зохион байгуулна.

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ УЛСЫН БАЙЦААГЧ

- Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий улсын ахлах байцаагч, улсын байцаагч төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад байна.
- Худалдан авах ажиллагааны улсын байцаагч нь худалдан авах ажиллагаанд тавих мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэхдээ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9-д заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - Энэ хуулийн 14.1.4, 14.1.6, 14.1.7-д заасан нөхцөл үүссэн нь тогтоогдсон тендерт оролцогчийг тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах санал гаргах.
 - Энэ хуулийн 57.2-т заасан зөрчил гаргасан албан тушаалтнуудыг төрийн албанаас чөлөөлүүлэх тухай дүгнэлт гаргаж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх.
 - Энэ хуулийн 42 дугаар зүйлд заасан хүчин төгөлдөр бус гэрээг цуцлах,
 - Гэрээний үүргийг гуравдагч этгээдэд захиалагчийн зөвшөөрөлгүйгээр шилжүүлсэн, тендерийн баримт бичигт урьдчилан заасан хувь хэмжээнээс хэтрүүлэн төлбөр хийсэн гэрээг цуцлах.

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО

- Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орсон албан тушаалтан дараах шаардлагыг хангасан байвал зохино.
 - Худалдан авах ажиллагааны чиглэлээр эсхүл тухайн бараа, ажил, үйлчилгээнд холбогдох чиглэлээр мэргэшсэн байх
 - Тендерт оролцогч болон түүнийг төлөөлөх этгээдийн эцэг, эх, хадам эцэг, эх, эхнэр, нөхөр, ах, эгч, дүү, хүүхэд биш байх
 - Сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцогчтой хөдөлмөрийн гэрээний харилцаанд ороогүй байх

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО

- Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын 2-оос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна. \47.4\
- Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна.

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО

- Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах журмуудыг батална:
 - Энэ хуулийн 47.4-т заасан үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг томилох, ажиллах журам
 - Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО

- Үнэлгээний хорооноос гаргасан шийдвэр /цаашид “үнэлгээний дүгнэлт” гэх/ нь хурлын тэмдэглэл хэлбэртэй байх бөгөөд хорооны гишүүдийн олонхи дэмжиж гаргасан шийдвэр, түүний үндэслэл, холбогдох бүх мэдээллийг агуулсан байна.
- Үнэлгээний дүгнэлтэд хорооны бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд эсрэг саналтай байсан гишүүн үнэлгээний дүгнэлтэд энэ тухайгаа тэмдэглэж гарын үсгээ зурна.

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО

- Үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байх бөгөөд дараах чиг үүрэгтэй байна.
 - Техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, тендерийн баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, нээх ажиллагааг холбогдох зааврын дагуу гүйцэтгэх
 - Тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг захиалагчид өгөх. Уг шийдвэрийг энэ хуулийн 46.2-т заасан захиалагчийг төлөөлх эрх бүхий албан тушаалтан үндэслэлгүйгээр өөрчлөхийг хориглоно. \47.2.2\

ШИЙДВЭРИЙН ТӨРӨЛ

ҮНЭЛГЭЭНИЙ
ХОРОО



ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ
/ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ
ОЛГОХ ЗӨВЛӨМЖ/



ЗАХИАЛАГЧ



ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ
ОЛГОХ ШИЙДВЭР



ШАЛГАРСАН
ТЕНДЕРТ
ОРОЛЦОГЧ



ГЭРЭЭНД ГАРЫН ҮСЭГ
ЗУРАХ